



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 122

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа,
үнийг шинэчлэн тогтоож, балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.6, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 29,620,026.05 (хорин есөн сая зургаан зуун хорин мянга хорин зургаан төгрөг таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 11,848,010.42 (арван нэгэн сая найман зуун дөчин найман мянга арван төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгөөр шинэчлэн тогтоож нэгдүгээр хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газрын харьяа "Хилийн цэргийн 0288 дугаар анги" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 96,784,800.40 (ерэн зургаан сая долоон зуун наян дөрвөн мянга найман зуун төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ, 58,070,880.36 (тавин найман сая далан мянга найман зуун наян төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газрын харьяа "Хилийн цэргийн 0288 дугаар анги" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй

3.Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Хошууч генерал Ж.Лхагвасүрэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал Х.Эрдэм-Ундрах нарт дор дурдсан арга хэмжээг авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгийн ашиглах хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

3.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын-ны өдрийн
..... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, ХИЛ
ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА "ХИЛИЙН ЦЭРГИЙН 0288 ДУГААР АНГИ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭЭРИЙН
ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо/дахин үнэлсэн огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/
1	Хавтас бүрэх машин, QLFM- 720Y	2020.12.31	ш	1	1,216,100.55	1,216,100.55	486,440.22	486,440.22	2
2	Хавтас говирддог машин, Saniyan	2020.12.31	ш	1	988,332.80	988,332.80	395,333.12	395,333.12	2
3	Огтолгооны машин, Polar 92X	2020.12.31	ш	1	26,655,062.80	26,655,062.80	10,662,025.12	10,662,025.12	2
4	Үдээсний машин, /Saniyan/	2020.12.31	ш	1	585,529.90	585,529.90	234,211.96	234,211.96	2
5	Сав баглаа боодлын машин, Zhong yong ji xie	2020.12.31	ш	1	175,000.00	175,000.00	70,000.00	70,000.00	2
				5		29,620,026.05		11,848,010.42	

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо/дахин үнэлсэн огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/
Нийт дүн									
				/		(хорин есөн сая зургаан зуун хорин мянга хорин зургаан төгрөг таван мөнгө)		(арван нэгэн сая найман зуун дөчин найман мянга арван төгрөг дөчин хоёр мөнгө)	



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2024 оны 03 дугаар сарын 14 ны өдрийн
 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ХИЛ ХАМГААЛАХ ӨРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
 "ХИЛИЙН ЦЭРГИЙН 0288 ДУГААР АНГИ" ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС
 БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгий нэр	Ашиглалтад орсон огноо/дахин үнэлсэн	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг төгрөг)
1	Цавууны машин EUROBING200	2020.12.31	ш	1	9,816,029.20	9,816,029.20	5,889,617.64	3,926,411.56
2	Хэвлэх машин Printmaster GTO	2020.12.31	ш	1	86,968,771.20	86,968,771.20	52,181,262.72	34,787,508.48
				2		96,784,800.40	58,070,880.36	38,713,920.04
	Нийт дүн					(ерэн зургаан сая долоон зуун наян дөрвөн мянга найман зуун төгрөг дөчин мөнгө)	(тавин найман сая далан мянга найман зуун наян төгрөг гучин зургаан мөнгө)	(гучин найман сая долоон зуун арван гурван мянга есөн зуун хорин төгрөг дөрвөн мөнгө)